



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2018

Э-сонин

3-Р САР

56-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2018.03.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	21
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	16,476,034,178.04
Хувьцаа	13,252,916,708.04
Засгийн газрын үнэт цаас /анхдагч/	
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	3,223,117,470
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	265,717,734
Хувьцаа	265,686,283
Засгийн газрын үнэт цаас /анхдагч/	
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	31,451
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	0
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	13,178


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	218
100% төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	12
Хувийн өмчийн	187
I ангилал	9
II ангилал	40
III ангилал	169

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	58
Брокер, Дилер	50
Андеррайтер	23
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Үнэт цаасны зах зээл

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны гишүүн компаниуд

/2018.03.31-ний байдлаар/

Сим бол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Дэлгэрхангай секюритиз ХХК	165,110	3,021,330,765.00	714,684	3,049,650,669.85	6,070,981,434.85
2	Мирэ Эссет Секьюритис Монгол	35,043,326	1,304,294,691	23,817,189	690,212,810	1,994,507,501.34
3	БиДиСек ХК	2,423,342	348,900,844.64	3,156,113	977,947,139.27	1,326,847,983.91
4	Голомт Капитал ХХК	3,671,060	508,133,920.00	7,421,107	536,376,300.25	1,044,510,220.25
5	Ти Ди Би Капитал ХХК	3,809,973	655,877,160.73	4,383,232	378,199,211.27	1,034,076,372.00
6	Новел инвестмент ХХК	3,552,130	328,584,355.48	6,168,419	396,221,827.47	724,806,182.95
7	Стандарт инвестмент ХХК	1,884,832	271,232,461.58	4,810,055	344,963,348.97	616,195,810.55
8	Ард капитал групп ХХК	1,293,318	273,701,269.95	446,053	306,831,787.47	580,533,057.42
9	Бумбат-Алтай ХХК	2,881,724	339,501,161.69	941,065	166,670,703.02	506,171,864.71
10	Батс ХХК	1,564,836	290,285,732.66	2,089,320	116,518,636.47	406,804,369.13
11	Ард секюритиз ХХК	1,301,863	136,070,788.40	1,816,682	236,360,135.56	372,430,923.96
12	Гаули ХХК	2,066,330	173,979,018.32	1,901,849	174,052,735.12	348,031,753.44
13	Блүмсбюри секюритиес ХХК	1,041,579	61,134,076.20	3,239,117	183,033,149.89	244,167,226.09
14	Гендекс ХХК	228,088	11,481,803.41	350,237	141,560,748.81	153,042,552.22
15	Лайфтайм инвестмент ХХК	42,029	139,021,574.00	235,825	9,171,368.64	148,192,942.64
16	Евразиа капитал монголиа ХХК	814,405	61,881,717.80	353,535	64,098,762.79	125,980,480.59
17	Гранддевелопмент ХХК	1,524,918	81,375,628.51	38,681	15,322,242.78	96,697,871.29
18	Монсек ХХК	529,260	41,739,546.99	473,547	47,084,711.73	88,824,258.72
19	Тэсо Инвестмент	109,759	34,246,840.00	733,554	49,614,680.99	83,861,520.99
20	Зэргэд ХХК	679,776	45,467,920.88	301,167	32,100,864.55	77,568,785.43

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.03.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	NEH	ДАРХАН НЭХИЙ	165,100	3,021,330,000.00	18,300.00	18,300.00	0.00	0.00
2	LEND	ЛэндМН ББСБ	42,186,372	2,144,679,321.71	66.00	28.75	46.26	0.00
3	TTL	ТАВАН ТОЛГОЙ	90,340	1,040,216,090.00	13,990.00	9,500.00	1,160.00	11.13
4	APU	АПУ	1,016,667	677,674,659.96	698.00	645.00	-22.32	-3.33
5	LEND	ЛэндМН ББСБ ХК	20,000,000	500,000,000.00	25.00	25.00	0.00	0.00
6	GOV	ГОВЬ	8,008	190,020,560.00	25,000.00	22,500.00	640.00	2.80
7	NEH	ДАРХАН НЭХИЙ	6,387	151,772,340.00	24,000.00	21,000.00	-1,400.00	-6.11
8	JIV	ЖИНСТ-УВС	63,667	105,231,375.00	2,000.00	1,335.00	309.00	22.07
9	MNP	МОНГОЛ ШУУДАН	95,610	52,810,235.15	594.50	520.00	31.46	5.72
10	SUU	СҮҮ	145,807	33,800,052.80	250.00	207.00	13.62	6.27
11	RMC	РЕМИКОН	855,195	32,175,852.86	41.80	35.20	-1.00	-2.56
12	ITLS	АЙТҮҮЛС	230,447	30,571,777.65	146.00	120.00	8.97	7.41
13	TCK	ТАЛХ ЧИХЭР	969	23,313,780.00	25,000.00	23,000.00	-1,720.00	-6.88
14	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	180	19,171,900.00	123,300.00	100,000.00	17,760.00	18.53
15	SHG	ШАРЫН ГОЛ	7,936	18,160,151.00	2,590.00	2,151.00	-150.00	-5.79
16	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	391	13,613,700.00	35,500.00	34,000.00	-480.00	-1.34
17	MRX	МЕРЕКС	399,359	13,541,642.80	39.00	29.20	7.00	21.88
18	UBH	УЛААНБААТАР ХИВС	763	12,760,180.00	17,000.00	15,490.00	1,510.00	9.75
19	BAN	БАГАНУУР	6,158	12,106,999.00	2,140.00	1,905.00	140.00	7.00
20	MMX	МАХИМПЕКС	3,552	11,659,133.00	3,600.00	2,700.00	658.00	25.00



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.03.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт /%/
			2018-03-01	2018-03-31		
1	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	1,739	4,637	8,095.00	3,458.00	74.57
2	ХҮННУ МЕНЕЖМЕНТ	9	62	93.81	32.12	52.07
3	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	41	505	767.91	262.91	52.06
4	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	450	115	172.00	57.00	49.57
5	Е-МОНИЕ	22	873	1,286.00	413.27	47.35
6	ТЕХНИК ИМПОРТ	9	15,010	20,700.00	5,690.00	37.91
7	ЖУУЛЧИН ГОВЬ	14	5,290	6,950.00	1,660.00	31.38
8	ТҮШИГ УУЛ	25,929	425	550.00	125.00	29.41
9	МАХИМПЕКС	3,552	2,632	3,290.00	658.00	25.00
10	МОНГОЛ ШИЛТГЭЭН	15,707	400	500.00	100.00	25.00
11	ЖИНСТ-УВС	63,667	1,400	1,709.00	309.00	22.07
12	МЕРЕКС	399,359	32	39.00	7.00	21.88
13	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	180	95,840	113,600.00	17,760.00	18.53
14	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	13,289	98	115.00	17.30	17.71
15	БҮТЭЭЛЧ ҮЙЛС	2	1,260	1,449.00	189.00	15.00
16	ДОРНОД ХУДАЛДАА	20	15,200	17,480.00	2,280.00	15.00
17	НАКО ТҮЛШ	2,660	110	126.50	16.50	15.00
18	ТАЛЫН ГАЛ	1	12	13.80	1.80	15.00
19	ТАВИЛГА	13	1,380	1,587.00	207.00	15.00
20	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	25	450	517.51	67.50	15.00

Ханшийн бууралттай хувьцаа

/2018.03.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2018-03-01	2018-03-31		
1	АР БАЯНХАНГАЙ	610	1,650	800.00	-850.00	-51.52
2	БӨӨНИЙ ХУДАЛДАА	1,015	500	341.00	-159.00	-31.80
3	МОНГОЛ НЭХМЭЛ	16	5,495	3,750.00	-1,745.00	-31.76
4	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	33,673	200	145.00	-55.00	-27.50
5	ХАРХОРИН	478	1,780	1,500.00	-280.00	-15.73
6	ОЛЛОО	8,942	80	68.00	-11.99	-14.99
7	БАЯН-АЛДАР	5	680	580.00	-100.00	-14.71
8	СОР	555	1,698	1,450.00	-248.00	-14.61
9	АВТО ЗАМ	117	4,710	4,100.00	-610.00	-12.95
10	БӨХӨГ	138	4,700	4,100.00	-600.00	-12.77
11	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	2,364	345	301.00	-44.00	-12.75
12	ЦАГААНТОЛГОЙ	5	3,400	2,995.00	-405.00	-11.91
13	МАТЕРИАЛИМПЕКС	1,063	10,600	9,500.00	-1,100.00	-10.38
14	МОГОЙН ГОЛ	410	8,900	7,995.00	-905.00	-10.17
15	ТАЛХ ЧИХЭР	969	25,000	23,280.00	-1,720.00	-6.88



“ЛЕНДМН ББСБ” ХК-ИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА НИЙЛҮҮЛТЭЭСЭЭ 16.5 ДАХИН ДАВЖ ХААГДЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2018 оны хамгийн анхны IPO болох “Лендмн ББСБ” ХК нь нийт хувьцааны 25%-ийг буюу 200 сая ширхэг хувьцааг олон нийтэд болон стратегийн хөрөнгө оруулагч нарт санал болгож анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс өнөөдөр буюу 03 дугаар сарын 07-ны өдрийн 13:00 цаг хүртэл авч дууслаа.

“Лендмн ББСБ” ХК-ийн олон нийтэд санал болгосон 12.5 хувь буюу 100 сая ширхэг хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад урьдчилсан байдлаар 6,551 хувь хүн, аж ахуйн нэгжүүд оролцож, нийтдээ 1,659,715,218 ширхэг үнэт цаасны худалдан авах захиалга өгсөн нь олон нийтэд санал болгосон 100 сая ширхэг хувьцааг 16.5 дахин давсан дүн юм.

“Лендмн ББСБ” ХК-ийн үнэт цаас худалдан авах захиалгуудаас хүснэгтийн дагуу биелүүлж, түүнээс дээш давсан дүнтэй захиалгад үнэт цаасыг хувь тэнцүүлэн хуваарилж, тайланг 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдөрт багтаан Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэх бөгөөд СЗХ-ноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж шийдвэр гаргасан үед хөрөнгө оруулагч нар хувьцаа авч чадаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийн буцаан авах эрх үүсэх юм.

“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛИЙН АНГИЛАЛ АХИУЛЛАА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн II ангиллын шалгуур шаардлагыг хангаж байгаа “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийг “Бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйлийн 20.2, 20.3.1 заалт болон компаниас ирүүлсэн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 17/02 тоот ангилал ахиулах тухай хүсэлтийг үндэслэн бүртгэлийн “III” ангиллаас ахиулан “II” ангилалд бүртгэхээр боллоо.

“ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ХОНХ ЦОХИХ” АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК нь Олон Улсын Санхүүгийн Корпораци /ОУСК/, , Компанийн Засаглалын Хөгжлийн Төв /КЗХТ/, Women Corporate Directors Монголын салбар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн Банк, МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран “*Жендерийн тэгш байдлын төлөө хонх цохих*” ёслолын арга хэмжээг зохион байгуулж, 5,675 удаагийн арилжааг нээлээ. Жил тутам зохион байгуулдаг тус арга хэмжээ нь хувийн хэвшлийн зүгээс дэлхийн эдийн засаг дахь эмэгтэйчүүдийн оролцоог дэмжин тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах талаар олон нийтэд таниулах зорилготой юм. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь тус арга хэмжээнд хоёр дахь жилдээ оролцлоо.

Энэ жилийн “Хонх цохих” арга хэмжээнд 59 хөрөнгийн бирж оролцсон бөгөөд МХБ 2 дахь жилдээ оролцлоо. Жендерийн тэгш байдлын төлөө тууштай, итгэл төгс ажиллана гэдэг байр сууриа эмэгтэйчүүдийг чадавхжуулах зарчмууд, ажлын байр, зах зээл, нийгэм дэх эмэгтэйчүүдийн чадавхийг нэмэгдүүлэх зөвлөмж зэрэгт гарын үсэг зурж олон нийтэд илэрхийлэхийг тус арга хэмжээнд оролцож буй байгууллагуудад уриалдаг билээ.

“ГУТАЛ” ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн №01 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 1,270 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг бүртгэлийг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн олгохоор шийдвэрлэсэн байна.



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК НЬ ДАВХАР БҮРТГҮҮЛЭХ АНХНЫ КОМПАНИЙН ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВЛАА

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга нь 2013 онд батлагдсанаар үнэт цаасны давхар бүртгэлийг нэвтрүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн билээ. Үнэт цаасны давхар бүртгэл гэдэг нь гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компани, дотоодын биржид бүртгүүлж үнэт цаасаа арилжих, дотоодын биржид бүртгэлтэй компани нь гадаадын биржид бүртгүүлэх ажиллагаа бөгөөд тус ажиллагааг зохицуулах нарийвчилсан журам болох “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ыг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хамтарсан ажлын хэсэг боловсруулж, Хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар баталсан билээ.

Хорооны энэхүү журамтай нийцүүлэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас үнэт цаасны давхар бүртгэлийг зохицуулах зохицуулалтыг тусган “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2018 оны 02 дугаар сараас эхлэн мөрдөж байгаа юм. Ийнхүү үнэт цаасны давхар бүртгэлийг зохицуулах хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдсэний үндсэн дээр, Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй компани “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д үнэт цаасаа давхар бүртгүүлэх хүсэлтээ 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр ирүүлээ. Энэхүү хүсэлтийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь холбогдох журмын дагуу ажлын 15 хоногт хянан шийдвэрлэнэ.

“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн №03/04 тоот тогтоолоор компанийн 2017 оны

цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 56.64 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг бүртгэлийн өдрийг 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөр тогтоож 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн компанийн байран дээр тараахаар шийдвэрлэсэн байна.

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 23 -ны өдрийн №01 тоот тогтоолоор компанийн 2017 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 10,000 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг бүртгэлийг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож 2018 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн компанийн байранд дээрээс олгох ба хэрэв хувьцаа эзэмшигчид хүссэн тохиолдолд харилцах данс руу нь шилжүүлэх замаар олгохоор шийдвэрлэсэн байна.

“СҮҮ” ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

“Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн тогтоолоор компанийн нийт хуримтлагдсан ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 3.00 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг бүртгэлийг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож 2018 оны 05 дугаар сарын 21-ны өдрөөс эхлэн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор багтаан “ҮЦТХТ” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.



ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДЫН 2017 ОНЫ 4-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ НИЙТЛЭГДЛЭЭ

2017 оны санхүүгийн жилд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн нийт 58 гишүүн үнэт цаасны компаниудаас 21 нь ашигтай ажиллаж, 28 нь алдагдалтай ажилласан үзүүлэлттэй байна. Ашигтай ажилласан тус 21 компанийн тайлант үеийн цэвэр ашгийн нийт хэмжээ 3.05 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.04 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт болсон бөгөөд цэвэр ашгийн үзүүлэлтээрээ "Ти Ди Би капитал ҮЦК" ХХК 1.2 тэрбум, "Би Ди Сек ҮЦК" ХК 1.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж тэргүүлээ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ОНЛАЙНААР АРИЛЖААНД ОРОЛЦОХТОЙ ХОЛБОГДОХ ТОДРУУЛГА

МХБ-ийн гишүүн үнэт цаасны компаниуд нь холбогдох журмын дагуу харилцагчдын захиалгыг утсаар, биечлэн, цахим шуудангаар болон өөрсдийн хөгжүүлсэн системийг ашиглан хүлээн авдаг.

МХБ-д одоогоор 58 гишүүн үнэт цаасны компани бүртгэлтэй бөгөөд тэдгээрээс цөөн тооны компаниуд нь харилцагчдыг алсаас арилжаанд оролцох боломжоор хангаад байна. Эдгээр компаниуд нь харилцагчдын захиалгыг өөрсдийн хөгжүүлсэн дотоод системээрээ дамжуулан МХБ-ийн арилжааны системд шууд оруулдаг бөгөөд системийн хэвийн ажиллагаа хангагдаж байгаа тохиолдолд хоцрогдол үүсэхгүй байх зарчимтай болно.

Харин зарим гишүүн үнэт цаасны компаниуд нь өөрийн хөгжүүлсэн дотоод системээр дамжуулан харилцагчдын захиалгыг онлайнаар хүлээн авдаг боловч тус дотоод систем нь МХБ-ийн Миллениум Ай Ти системд шууд холбогдоогүйн улмаас онлайнаар хүлээн авсан захиалгуудыг өөрийн дотоод системээс МХБ-ийн арилжааны системд гар аргаар шивж оруулдаг нь хугацааны хувьд илүү хоцрогдол

үүсэх нөхцөл болдог.

Иймд хөрөнгө оруулагчид та бүхэн үйлчлүүлж буй үнэт цаасны гишүүн компаниуддаа захиалгаа онлайнаар өгч байгаа тохиолдолд, тус компанийн захиалга авах систем нь МХБ-ийн арилжааны системд шууд холбогддог эсэх, хэдий хугацааны хоцрогдол үүсдэг зэргийг тодруулахыг зөвлөж байна.

"МОНГОЛ ШУУДАН" ХК НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭГЭЭ НЭМЭГДҮҮЛЛЭЭ

"Монгол Шуудан" ХК-ийн 2017 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангаар цэвэр ашгийн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 20 -ны өдрийн №18/04 тоот тогтоолоор компанийн цэвэр ашгийн 30 хувь буюу нэгж хувьцаанд 3.68 төгрөг, нийт 367,247,033 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн "ҮЦТХТ" ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 18/01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN